

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/01-НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Утас: 7036-3040	Ч.Энхтуяа Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Утас: 7036-3036	Б.Батмөнх Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Утас: 7036-2442	Т.Болор Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-6
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	7-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-33
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	27
4. Аудитын тайлан	34
4.1 Ерөнхий зүйл	34
4.2 Материаллаг байдал	34
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	34
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	35
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	37
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	38
5. Аудитын илрүүлэлт	39-47
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	48-49

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНСАХЗ	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төрийн албан хаагч
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УБТЗ	Улаанбаатар Төмөр зам
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ШХА	Шууд худалдан авалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ ТАНАА**

2025.04.27 № СЭА-2025/01-НА-СТА-ТЭС
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс жил бүр тогтмол гардаг, урьдчилан төлөвлөх боломжтой, аймгийн ЗДТГ-ын болон бусад байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлэх **77.3** сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлж, зориулалт бусаар зарцуулсан,
- ЗДҮАХХ-ийн батлагдсан төсвөөс улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон бусад урсгал зардалд нийт 413.6 сая төгрөгийг зарцуулсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин аймгийн ТЭС нь 2 байгууллагын ойн арга хэмжээнд **19.8** сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн,

43250254 4

- ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас сумдын ХХС-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар 8 сумын 211 иргэнээр хугацаа хэтэрсэн зээлийн алдангийг төлүүлээгүй зөрчилд 243.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг хангуулахдаа 8 сумын ХХС-ийн эх үүсвэрээс **153.9** сая төгрөгийг аймгийн төсвийн нэр заагдаж, ангилагдаагүй бусад орлогын дансанд төвлөрүүлсэн,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс авлагын дансанд бүртгэлтэй, насжилт өндөртэй, 1990-2000 оны хооронд үүссэн 276.5 сая төгрөгийн авлагад дүн шинжилгээ хийгээгүй, үр дүнг шийдвэрлээгүй,
- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 9 байгууллага 60.6 сая төгрөгийн авлага, 10 байгууллага **67.2** сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- 9 ААТҮГ 529.1 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй буюу анхан шатны хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэсэн,
- 19 байгууллага албан хаагчдын цалин, нэмэгдэл, урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож, нийт **73.9** сая төгрөг илүү олгосон,
- 19 байгууллага орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас **41.2** сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй,
- 2 байгууллага цалингийн зардлаас **4.1** сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт тооцож олгосон,
- 2 байгууллага төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалин, НДШ **16.2** сая төгрөгийг төсвөөс барагдуулсан боловч гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй гэх мэт.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2024 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 135,528.4 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 109,717.0 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 81.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 19.0 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль”-д Сэлэнгэ аймаг нь 2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 2,308.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тусгасан боловч 428.5 сая төгрөгөөр дутуу буюу 1,879.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын 2025 оны 21 дүгээр тогтоолоор “Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,453,373.1	66,154,175.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,955,729.2	39,814,758.6
33	АВЛАГА	15,447,245.2	13,063,833.0
34	УРЬДЧИЛГАА	2,177,544.9	2,229,164.5
35	БАРАА МАТЕРИАЛ	10,866,182.4	11,035,316.3
36	НӨӨЦИЙН БАРАА	6,671.2	11,102.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	159,631,171.5	191,082,751.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	159,631,171.5	191,082,751.8
39200	Биет хөрөнгө	147,213,332.7	171,959,325.9
39300	Биет бус хөрөнгө	12,417,838.8	19,123,425.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	211,084,544.5	257,236,927.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,203,171.6	24,894,639.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,030,129.0	24,843,634.6
41200	Богино хугацаат зээлийн өглөг	373,180.9	373,180.9
41300	Өглөг	17,614,910.9	24,451,564.5
41400	Урьдчилж орсон орлого	42,037.2	18,889.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	173,042.6	51,004.5
42200	Урт хугацаат зээл	173,042.6	51,004.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	192,881,372.9	232,342,287.9
51	Засгийн газрын хувь оролцоо	192,881,372.9	232,342,287.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	41,162,311.4	43,491,656.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	5,080,488.6	6,880,260.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	17,968,582.6	18,945,588.2
51200	Хуримтлагдсан үр дүн	83,301,262.3	122,738,589.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,368,728.1	40,286,193.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	211,084,544.5	257,236,927.0

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН -I	135,078,991.0	184,901,471.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	64,809,717.2	84,146,036.1
110	Орлогын албан татвар	49,776,377.6	67,743,288.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,398,192.6	43,756,117.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,671,857.1)	(2,193,806.8)
1103	ААН-ын орлогын албан татвар	21,050,042.1	26,180,977.3
113	Хөрөнгийн албан татвар	4,726,870.9	5,088,651.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	10,306,468.8	11,314,095.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,975,773.9	75,266,039.8
120	Нийтлэг татварын бус орлого	30,603,224.0	48,252,914.3
121	Хөрөнгийн орлого	171,998.7	228,556.6
122	Тусламжийн орлого	30,000.0	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	20,170,551.2	26,784,568.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,293,499.8	25,489,395.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	81,833,291.5	94,639,546.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,321,239.7	88,732,601.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,995,027.9	83,016,277.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,790,040.0	24,777,728.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,968,180.6	3,047,849.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,126,108.0	18,939,132.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,637,468.0	1,768,328.2
2105	Нормативт зардал	28,208.1	20,199.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,235,434.0	2,557,513.1
2107	Томилолт, зочны зардал	366,740.4	455,595.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,288,325.4	11,786,702.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,554,523.2	19,663,229.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,326,211.8	5,716,324.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,512,051.8	5,906,945.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН -III=-I--II	53,245,699.4	90,261,924.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	480.5	35,189.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,205,812.4	47,616,460.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН -VI=-III+-IV--V	15,040,367.5	42,680,653.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,317,139.8	-	190,317,139.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(410,180.6)	-	(410,180.6)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,906,959.1	-	189,906,959.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,165,137.1)	-	(5,165,137.1)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(2,195,274.2)	-	(2,195,274.2)
7	Өмчид гарсан өөрчлөлт	2,012,567.6	-	2,012,567.6
9	Тайлант үеийн үр дүн	8,322,257.5	-	8,322,257.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,881,372.9	-	192,881,372.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	192,881,372.9	-	192,881,372.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(57,283.1)	-	(57,283.1)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,824,089.8	-	192,824,089.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,347,499.3)	-	(5,347,499.3)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,538,871.6	-	1,538,871.6
17	Өмчид гарсан өөрчлөлт	3,875,633.9	-	3,875,633.9
19	Тайлант үеийн үр дүн	39,451,191.8	-	39,451,191.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,342,287.9	-	232,342,287.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	118,358,338.2	171,607,852.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	55,659,840.6	83,894,712.9
110	Орлогын албан татвар	40,610,976.5	67,743,288.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,398,192.6	43,756,117.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,671,857.1)	(2,193,806.8)
1103	ААН-ын орлогын албан татвар	11,884,641.0	26,180,977.3
113	Хөрөнгийн албан татвар	4,742,673.1	5,088,651.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	10,306,191.0	11,062,772.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,130,154.9	2,625,168.4
1181	Газрын төлбөр	2,891,486.7	3,450,521.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,284,549.4	4,987,083.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,119,722.4	61,232,558.4
120	Нийтлэг татварын бус орлого	23,747,172.5	34,219,433.0
121	Хөрөнгийн орлого	171,998.7	228,556.6
122	Тусламжийн орлого	30,000.0	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	20,170,551.2	26,784,568.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,578,775.2	26,480,581.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,082,216.8	95,637,605.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,082,216.8	95,637,605.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,757,429.7	89,723,352.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,194,786.7	32,944,995.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,934,150.4	4,518,237.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,621,264.1	22,694,273.3
2104	Хангамж, бараа материалын зардал	8,819,034.2	10,560,049.0
2105	Нормативт зардал	29,107.0	27,073.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	927,458.7	2,577,364.6
2107	Томилолт, зочны зардал	364,226.4	460,989.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,573,608.5	5,543,992.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,293,793.6	10,396,377.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,324,787.2	5,914,253.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	40,276,121.4	75,970,247.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,300,884.9	1,370,403.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,021,238.0	59,981,752.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,021,238.0	59,981,752.6
2200	Дотоод эх үүсвэрээр	48,021,238.0	59,981,752.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(46,720,353.1)	(58,611,349.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,915,731.6)	(500,278.0)
14	Бусад эх үүсвэр	33,000.0	1,564,781.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,762,178.0	363,401.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	186,553.6	1,701,657.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(8,359,963.3)	16,858,620.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,315,692.6	22,955,729.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,955,729.2	39,814,758.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,528,428.2	109,717,038.4	(25,811,389.8)	81.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,296,315.8	71,797,279.8	(8,499,036.0)	89.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,981,851.6	66,045,726.8	(6,936,124.8)	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,357,819.5	24,739,186.9	(2,618,632.6)	90.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,490,052.0	3,056,103.0	(433,949.0)	87.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,147,403.6	18,845,712.6	(1,301,691.0)	93.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,603,626.9	1,483,961.2	(119,665.7)	92.5
2105	Нормативт зардал	28,648.3	23,114.0	(5,534.3)	80.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,971,442.3	2,828,474.7	(142,967.6)	95.2
2107	Томилолт, зочны зардал	524,780.2	450,969.6	(73,810.6)	85.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,515,690.4	4,344,307.1	(1,171,383.3)	78.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,342,388.4	10,273,897.7	(1,068,490.7)	90.6
212	ТАТААС	125,966.1	125,966.1	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	125,966.1	125,966.1	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,188,498.1	5,625,586.9	(1,562,911.3)	78.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,626,368.8	3,606,193.3	(1,020,175.6)	77.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,562,129.3	2,019,393.6	(542,735.7)	78.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,419,196.5	37,556,357.4	(14,862,839.1)	71.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,812,915.9	363,401.3	(2,449,514.6)	12.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	135,528,428.2	113,776,354.6	(21,752,073.7)	84.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	678,664.9	-	(678,664.9)	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	123,033,535.4	111,684,190.7	(11,349,344.7)	90.8
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,816,227.9	2,092,163.9	(9,724,064.0)	17.7
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-	-	-
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,922,306.9	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,981,623.0	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	889	843	(46)	94.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	46	46	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	843	797	(46)	94.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,100,438.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,080,438.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,602,702.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,146.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	896.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,468.6
2104	Хангамж, бараа материалын зардал	58,647.3
2105	Нормативт зардал	3,959.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	291,689.2
2107	Томилолт, зочны зардал	10,020.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224,405.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,993,470.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,477,735.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,782.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,344,953.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,100,438.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,100,438.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч *Цаашид Аймгийн ТЕЗ гэх* нь *“Хүнээ дээдэлж, хамтдаа хөгжье” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 2024 оныг “Аялал жуулчлал, ногоон хөгжлийн жил” болгон үйл ажиллагаа явуулсан байна.*

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын бүрэн эрхийг дараах байдлаар тусгасныг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;
- Аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх;
- Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
- Гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийг баталсан,
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийсэн гэх мэт.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө “дунд” гэж үзлээ.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тус чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 онд 31 байгууллагад дотоод аудит, 25 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 128 байгууллагын шилэн дансанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн дараах алдаа, зөрчлийг илрүүлсэн байна. Үүнд:

- 17 байгууллагын 280.7 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт,
- 49 байгууллагын 17,012.6 сая төгрөгийн зөрчилд 148 албан шаардлага,
- 53 байгууллагын 5,029.7 сая төгрөгийн зөрчилд 182 зөвлөмж,

Дээрх төлбөрийн актын 64.9 хувийг, албан шаардлагын 70.7 хувийг, зөвлөмжийн 38.8 хувийг биелсэн дүн мэдээтэй тайлагнасан байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд сумдын ХХС-ийн 2022-2023 оны үйл ажиллагааг хамруулан хийсэн дотоод аудитаар 8 сумын 211 иргэнээр хугацаа хэтэрсэн зээлийн алдангийг тооцож, төлүүлээгүй зөрчилд 243.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон нь нийт актын 86.7 хувийг эзэлж байна.

Гэвч тус албанаас төлбөрийн актыг зээлийн хугацаа хэтрүүлсэн этгээдүүдээр бус 8 сумын ХХС-ын эх үүсвэрээс 153.9 сая төгрөгийг аймгийн төсвийн орлогын дансанд шилжүүлсэн нь зөрчлийг арилгах бус хэлбэрийг өөрчилж, ЖДҮ-ийг дэмжих зориулалт бүхий уг сангийн эх үүсвэрийг бууруулж, зорилго зорилтыг алдагдуулсан сөрөг үр дагавар үүсгэсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1 дэх “Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ: 2.1.5 “хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд

ногдуулсан алданги” гэсэн заалттай нийцэхгүй байна. Төлбөрийн актыг сумын ХХС-аас аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлснээс шалтгаалан зарим сумд нь эх үүсвэргүй болж зээл олгогдоогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд 9 сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны үр дүнд дотоод аудит хийж гүйцэтгэсэн боловч аудитын хамрах хүрээнд тусгагдаж төлөвлөгдсөн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт зарцуулалт, үр дүн, төсвийн орлогын бүрдүүлэлт, ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн гэх мэт асуудлуудад чиглэгдээгүй, илрүүлсэн зөрчил нь санхүүгийн хяналт шалгалтын буюу нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой байна.

Иймд бид аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн ТЕЗ-ийн харьяаны төсөвт байгууллагууд, сумдын төрийн сан, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Дээрх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,152.4 сая төгрөгөөр буюу 21.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,955.7	39,814.7	16,859.0
Авлага	15,447.2	13,063.8	(2,383.4)
Урьдчилгаа	2,177.5	2,229.2	51.7
Бараа материал	10,866.2	11,035.3	169.1
Нөөцийн бараа	6.7	11.1	4.4
Үндсэн хөрөнгө	159,631.2	191,082.8	31,451.6
Нийт хөрөнгө	211,084.5	257,236.9	46,152.4
Өр төлбөр	18,203.2	24,894.6	6,691.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	192,881.3	232,342.3	39,461.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	211,084.5	257,236.9	46,152.4

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 39,814.7 сая төгрөг болж, өмнөх оноос 16,859.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	18.2	6.7	-11.5
Банканд байгаа бэлэн мөнгө	22,937.5	39,808.0	16,870.5
Төрийн сангийн харилцах	19,893.7	35,526.0	15,632.3
Арилжааны банк дахь харилцах	3,043.8	4,282.0	1,238.2
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	-	-
Дүн	22,955.7	39,814.7	16,859.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 39,814.7 сая төгрөг нь дараах байдлаар байршиж байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит 7 үйлдвэрийн газрын касс бэлнээр 6.7 сая төгрөг,
- Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 886.4 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 8,565.8 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 1,884.4 сая төгрөг,
- 17 сумын ТТЗ болон түүний харьяа байгууллагуудын харилцах дансанд 24,189.4 сая төгрөг,
- Орон нутгийн өмчит 22 үйлдвэрийн газрын арилжааны банкин дахь харилцах дансанд 4,282.0 сая төгрөг гэх мэт.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 39,814.7 сая төгрөгийн 47.6 хувийг төсөл, сан, 41.7 хувийг төрийн сан, 10.7 хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл тус тус эзэлж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 13,063.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,383.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	21.4	44.1	22.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	11.3	11.3
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	245.9	224.0	(21.9)
Дансны авлага /ОНӨААТҮГ/	5,158.9	4,392.6	(766.3)
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨААТҮГ/	6.6	32.5	25.9
Бусад авлага	5,025.5	4,612.3	(413.2)
Зээлийн авлага	4,988.9	3,747.0	(1,241.9)
Дүн	15,447.2	13,063.8	(2,383.4)
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	5,160.0	4,023.4	(1,136.6)
Төсөл/ сан	200.2	154.5	(45.7)
Төрийн сан	317.9	317.8	(0.1)
ОНӨААТҮГ	9,769.1	8,568.1	(1,201.0)
Дүн	15,447.2	13,063.8	(2,383.4)

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 8,164.6 сая төгрөг буюу 62.5 хувийг дараах ОНӨААТҮГ-ын авлагууд эзэлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ 3,020.4 сая төгрөг буюу 37.0 хувь /хуваарийн дагуу төлөх орон сууцны төлбөр/
- “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ 2,195.4 сая төгрөг буюу 26.9 хувь,
- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ 1,266.1 сая төгрөг буюу 15.5 хувь,
- “Гавшгай ус” ОНӨААТҮГ 1,682.7 сая төгрөг буюу 20.6 хувийг гэх мэт.

Авлагын үлдэгдэлд 3 жилээс дээш насжилттай 10,329.0 сая төгрөгийн авлага байгаа бөгөөд үүний 91.5 хувийг буюу 9,452.5 сая төгрөгийг дараах авлагууд эзэлж байна. Үүнд:

- УТХО-ын 830.7 сая төгрөгийн авлага 9.4 хувийг эзэлж байна /хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг УТХО-ын данснаас орон нутгийн дансанд шилжүүлснээс үүссэн авлага/
- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын 1,247.8 сая төгрөгийн авлага 14.1 хувийг,
- 16 сумын ХХС-ийн зээл, зээлийн хүүгийн 2,181.3 сая төгрөгийн авлага 21.1 хувийг,
- “Сэлэнгэ Цэнгэг ус” ОНӨААТҮГ-ын 2,172.2 сая төгрөгийн авлага 24.5 хувийг,
- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 3,020.4 сая төгрөгийн авлага 34.0 хувийг эзэлж байна.

Дээрх олон жилийн насжилттай авлагуудын зарим эзэн холбогдогч нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхой бус байдлаас болж шүүхэд хандах боломжгүй, зарим авлагын хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон байна.

ХХС-ийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулснаар эргэн төлөлт харьцангуй нэмэгдэж байгаа ч хугацаа хэтэрсэн үлдэгдэл их байгаа нь сангийн эх үүсвэр бүрдэхгүй байх, эргэц удаашрах, төсвийн хөрөнгө үрэгдэх эрсдэл, үр дагаврыг бий болгож байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас аймгийн ХААГ 28.0 сая төгрөг Алтанбулаг сумын ЗДТГ 19.5 сая төгрөг, Жавхлант сумын ЗДТГ 0.5 сая төгрөг, Зүүнбүрэн сумын ЗДТГ 3.0 сая төгрөг, зэрэг нийт 9 байгууллага **60.6** сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- Зүүнбүрэн сумын ХХС, Туулын хишиг ОНӨААТҮГ 27.3 сая төгрөг, Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 10.2 сая төгрөг, Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ 5.9 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2,229.2 сая төгрөг болж, өмнөх оноос 3,252.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,177.5	2,229.2	51.7
Дүн	2,177.5	2,229.2	51.7
Үүнээс байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	2,163.8	2,201.1	37.3
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ОНӨААТҮГ	13.7	28.1	14.4
Дүн	2,177.5	2,229.2	51.7

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 51.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд бүрэн хэрэгжиж дуусаагүй ОНХС-аар хэрэгжүүлэх 13.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг хөрөнгө оруулалтын данснаас урьдчилгаа дансанд шилжүүлж, бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд УТХО-ын 1,809.0 сая төгрөг, ОНХС-ийн 229.1 сая төгрөг, ОНХО-ын 139.2 сая төгрөгийн бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 2024 оны А/644 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Мандал сумын ИТХ 1.8 сая төгрөг, аймгийн ИТХ 25.5 сая төгрөгийн гэрээт 2 ажлыг хүлээж аваагүй байхад урьдчилж төлсөн зардлаар бус тайлант оны зардалд бүртгэж тайлагнасан.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 11,035.3 сая төгрөг болж, өмнөх оноос 169.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	477.9	772.9	295.0
Эм боох материал	2.9	2.9	-

Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	78.4	101.3	22.9
Бичиг хэргийн материал	125.1	114.2	(10.9)
Аж ахуйн материал	1,687.5	1,680.4	(7.1)
Сэлбэг хэрэгсэл	930.3	865.5	(64.8)
Түлш, шатах тослох материал	27.3	29.3	2.0
Барилгын засварын материал	1,090.4	542.2	(548.2)
Хүнсний материал	4.1	11.7	7.6
Бусад хангамжийн материал	6,178.7	6,570.5	391.8
Биологийн хөрөнгө	7.0	7.0	-
Мал амьтад	256.6	337.4	80.8
Дүн	10,866.2	11,035.3	169.1
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	8,434.0	8,449.9	15.9
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ОНӨААТҮГ	2,432.2	2,585.4	153.2
Дүн	10,866.2	11,035.3	169.1

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 169.1 сая төгрөгөөр өсөхөд дараах ажил гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 33,485.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан,
- 892.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан,
- 12,398.3 сая төгрөгийн бараа материал зарцуулсан,
- 17,370.0 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн,
- 4,440.4 сая төгрөгийн бараа материалыг акталсан гэх мэт.

Бусад хангамжийн материалын үлдэгдлийн 69.7 хувь буюу 4,579.6 сая төгрөг нь Баянгол, Мандал сумдын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн дуусаагүй төсөл, арга хэмжээнүүдийг хуримтлуулан бүртгэснээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Баянгол сумын ОНХС-ийн 979.1 сая төгрөг, ОНХО-ын 303.0 сая төгрөг,
- Мандал сумын ОНХС-ийн 2,633.0 сая төгрөг, ОНХО-ын 664.5 сая төгрөг.

Аудитын илрүүлэлт:

- Сайхан сумын ЗДТГ 20.0 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч бүртгээгүй,
- 7 ААТҮГ 502.8 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй.

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 11.1 сая төгрөг болж, өмнөх оноос 4.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нөөцийн барааны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	-	7.9	7.9
Бусад нөөц	6.7	3.2	(3.5)

Дүн	6.7	11.1	4.4
------------	------------	-------------	------------

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансны үлдэгдэл өссөн нь өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор Жавхлант сум 7.9 сая төгрөгийн өвс, тэжээлийн нөөц, Сүхбаатар сумын орон сууцны дулааны тогтвортой байдлыг хангах, тохиолдох гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 3.2 сая төгрөгийн нүүрсний нөөц бүрдүүлснээс шалтгаалсан байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 191,082.8 сая төгрөг болж, өмнөх оноос 31,451.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	147,213.4	171,959.4	24,746.0
Барилга, байгууламж, орон сууц	78,290.9	86,019.7	7,728.8
Хуримтлагдсан элэгдэл	(11,817.6)	(14,278.0)	(2,460.4)
Авто тээврийн хэрэгсэл	10,094.8	13,394.2	3,299.4
Хуримтлагдсан элэгдэл	(4,755.4)	(5,463.3)	(707.9)
Машин тоног төхөөрөмж	12,110.3	17,208.6	5,098.3
Хуримтлагдсан элэгдэл	(6,074.3)	(6,721.1)	(646.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,590.5	3,005.8	415.3
Хуримтлагдсан элэгдэл	(1,490.9)	(1,545.7)	(54.8)
Зам, гүүрний байгууламж	46,265.6	53,166.3	6,900.7
Хуримтлагдсан элэгдэл	(13,020.5)	(15,683.9)	(2,663.4)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14.3	14.3	-
Бусад үндсэн хөрөнгө	39,479.7	47,852.0	8,372.3
Хуримтлагдсан элэгдэл	(13,073.4)	(15,937.6)	(2,864.2)
Дуусаагүй барилга, байгууламж	8,473.5	10,797.3	2,323.8
Ном	125.9	130.8	4.9
Биет бус хөрөнгө	12,417.8	19,123.4	6,705.6
Программ хангамж	253.5	262.4	8.9
Хуримтлагдсан элэгдэл	(138.0)	(168.8)	(30.8)
Бусад биет бус хөрөнгө	12,345.3	19,075.5	6,730.2
Хуримтлагдсан элэгдэл	(43.0)	(45.7)	(2.7)
Дүн	159,631.2	191,082.8	31,451.6
Үүнээс байгууллагын төрлөөр:			-
Төсөвт байгууллага	86,291.1	122,621.6	36,330.5
Төсөл/ сан	1.9	1.1	(0.8)
Төрийн сан	-	-	-
ОНӨААТҮГ	73,338.2	68,460.1	(4,878.1)
Дүн	159,631.2	191,082.8	31,451.6

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 31,451.6 сая төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,513.6 сая төгрөг,
- Балансаас баланст шилжүүлэн авсан 17,289.8 сая төгрөг,
- Хандиваар болон бусад 28,562.0 сая төгрөг,

- Дахин үнэлгээний нэмэгдэл 72.1 сая төгрөг зэрэг нийт 50,437.5 сая төгрөгөөр нэмэгдэж,
- Балансаас баланст шилжүүлсэн 948.7 сая төгрөг,
- Акталсан болон бусад 3,267.8 сая төгрөг
- Дахин үнэлгээний хорогдол 5,338.3 сая төгрөг зэрэг нийт 9,554.8 сая төгрөгийн бууралтаас.

Хандиваар болон бусад бусад ангиллаар орлого авсан хөрөнгийн дүн 28,562.0 сая төгрөгөөр өсөхөд дараах ажил, гүйлгээ голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй газруудыг 2,221.6 сая төгрөгөөр үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэсэн,
- Мандал сумын ЗДТГ нь УТХО-аар хэрэгжүүлсэн 2,392.9 сая төгрөгийн “Ахмадын төвийн барилга”-ыг орлогод авсан, тус ЗДТГ-т бүртгэлтэй газруудыг 1,249.9 сая төгрөгөөр үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэсэн,
- Ерөө сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1,362.5 сая төгрөгийн барилга, байгууламж, 1,919.9 сая төгрөгийн зам гүүрийн байгууламжийг орлогод авсан,
- Баруунбүрэн сумын ЗДТГ нь УТХО-аар хэрэгжүүлсэн 2,781.2 сая төгрөгийн “Сумын төв доторх 2.5 км автозам”-ыг орлогод авсан,
- Сайхан сумын ЗДТГ нь УТХО-аар хэрэгжүүлсэн 2,527.3 сая төгрөгийн “Залуучууд хөгжлийн ордон”-ыг орлогод авсан.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар сумын ЗДТГ, Орхонтуул сумын ЗДТГ 124.1 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй,
- Мандал энерго ОНӨААТҮГ-ын эзэмшилд байхгүй хөрөнгийн 0.4 сая төгрөгийн татварыг төлсөн.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 24,894.6 сая төгрөг болж, өмнөх оноос 6,691.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	17,988.2	24,824.7	6,836.5
Богино хугацаат зээлийн өглөг	373.2	373.2	-
Арилжааны банк	373.2	373.2	-
Өглөг	3,322.8	8,867.9	5,545.1
Ажилчидтай холбогдсон өглөг	192.0	295.2	103.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	35.2	6.9	(28.3)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	3,052.3	8,565.8	5,513.5
Зээлийн хүүгийн өглөг	43.3	-	(43.3)
Бусад өглөг	14,292.2	15,583.6	1,291.4
Байгууллагад төлөх өглөг	808.4	1,292.0	483.6
Хувь хүмүүст төлөх өглөг	11.8	17.7	5.9
Татварын өглөг /ОНӨААТҮГ/	5,061.0	6,235.3	1,174.3
НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/	4,342.6	5,134.3	791.7

Ноогдол ашгийн өглөг /ОНӨААТҮГ/	2.0	2.0	-
Дансны өглөг /ОНӨААТҮГ/	4,066.4	2,902.3	(1,164.1)
Урьдчилж орсон орлого	42.0	18.9	(23.1)
Урт хугацаат өр төлбөр дүн	173.0	51.0	(122.0)
Арилжааны банк	161.7	39.7	(122.0)
Бусад урт хугацаат өр төлбөр /ОНӨААТҮГ/	11.3	11.3	-
Дүн	18,203.2	24,894.6	6,691.4
Үүнээс байгууллагын төрлөөр:			-
Төсөвт байгууллага	3,489.1	9,490.7	6,001.6
Төсөл, сан	260.5	238.7	(21.8)
Төрийн сан	7.7	40.9	33.2
ОНӨААТҮГ	14,445.9	15,124.3	678.4
Дүн	18,203.2	24,894.6	6,691.4

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь өмнөх онд УТХО-аар бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээний 6,773.6 сая төгрөгийн өглөг нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт өр төлбөрийн 90.7 хувь буюу 22,578.6 сая төгрөгийг дараах өглөгүүд бүрдүүлж байна. Үүнд:

- 40.2 хувийг буюу 9,064.9 сая төгрөгийг “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын өглөг,
- 37.9 хувийг буюу 8,565.8 сая төгрөгийг ОНХС, УТХО, ОНХО-ын өглөг,
- 12.0 хувь буюу 2,705.7 сая төгрөгийг “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын өглөг,
- 9.9 хувь буюу 2,242.2 сая төгрөгийг “Гавшгай ус” ААТҮГ-ын өглөгүүд тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 51.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй дараах 2 аж ахуйн нэгж байна. Үүнд:

- Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ нь 2013 онд ХХС-аас 20.0 сая төгрөгийн зээл авсан, 11.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, үйл ажиллагаа явуулаагүй 5 жил болсон учраас зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй,
- Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ нь хөрөнгө оруулалтын зориулалтаар арилжааны банкнаас 2020, 2021 онд 2 удаа нийт 350.0 сая төгрөгийн сарын 1.3-1.4 хувийн хүүтэй зээл авсан, зээлийн төлбөр хугацаандаа хэвийн төлөгдөж, 39.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Алтанбулаг сумын ИТХ 0.7 сая төгрөг, Алтанбулаг сумын ЗДТГ 29.1 сая төгрөг, Баянгол сумын ИТХ 2.9 сая төгрөг зэрэг нийт 10 байгууллага **67.2** сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./
- Жавхлант сумын ЗДТГ 0.5 сая төгрөг, Мандал сумын Түнхэл захирагчийн алба 1.9 сая төгрөг, Орхонтуул сумын ЗДТГ 0.3 сая төгрөг, Сант сумын ЗДТГ 0.4 сая төгрөг зэрэг нийт **3.0** сая төгрөгийн өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй өр төлбөрийг тайлант оны төсвөөс төлж барагдуулсан,
- Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ 56.0 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 232,342.3 сая төгрөг болж, өмнөх оноос 39,461.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	40,970.5	43,491.6	2,521.1
Өмч /төрийн/ /ОНӨААТҮГ/	5,272.3	6,880.3	1,608.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ОНӨААТҮГ/	17,968.6	18,945.6	977.0
Хуримтлагдсан үр дүн	83,301.2	122,738.6	39,437.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,368.7	40,286.2	(5,082.5)
Дүн	192,881.3	232,342.3	39,461.0
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	108,037.2	147,187.3	39,150.1
Төсөл, сан	342.4	383.3	40.9
Төрийн сан	10,325.7	15,962.3	5,636.6
ОНӨААТҮГ	74,176.0	68,809.4	(5,366.6)
Дүн	192,881.3	232,342.3	39,461.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 39,461.0 сая төгрөгөөр өсөхөд дараах өөрчлөлтүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Тайлант оны хуримтлагдсан үр дүн 39,437.4 сая төгрөгөөр өссөн,
- “Цант орхон” ААТҮГ нь хөрөнгийн дахин үнэлгээ хийж, дахин үнэлгээний зөрүүг 5,338.3 сая төгрөгөөр бууруулсан.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 6 ОНӨААТҮГ, 6 ТТЗ-ийн өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 57.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 10. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн судалгаа

№	Байгууллага	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн
1	Сэлэнгэ-Энерго	-	-	29.5
2	Цант Орхон ААТҮГ	(43.4)	-	44.6
3	Мандал Энерго	-	-	(4.8)
4	Тохилог Хараа ААТҮГ	-	-	0.2
5	Хүдэр ойн анги ОНӨААТҮГ	-	-	(54.9)
6	Сэлэнгэ орон сууц	-	-	(2.3)
7	Ерөө сумын ХХС	-	-	(17.8)
8	Мандал сумын ХХС	-	-	(7.7)
9	Орхон сумын ОНӨО	-	-	(8.8)
10	Цагааннуур сумын ХХС	-	-	7.1
11	Сайхан сумын ХХС	-	-	(8.2)
12	Орхонтуул сумын ЗДТГ	-	-	9.2
	Дүн	(43.4)	-	(13.9)

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой материаллаг хэмжээний залруулгыг тодруулбал:

- “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь өмнөх оны хуримтлагдсан авлага, өглөгийн үлдэгдэлд холбогдох байгууллагуудын шийдвэрийг үндэслэн залруулга хийж 29.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- “Цант Орхон” ОНӨААТҮГ-ын дахин үнэлгээтэй, үлдэх өртөгтэй хөрөнгө актлагдсанаас хуримтлагдсан үр дүнг 1.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- “Хүдэр ойн анги” ОНӨААТҮГ нь 2023 онд хандиваар авсан хөрөнгийг буруу бүртгэсэнтэй холбоотой хуримтлагдсан үр дүнг 54.9 сая төгрөгөөр бууруулсан,
- “Ерөө сумын ХХС” нь Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 6-р сарын 14-ны өдрийн 03/3201 тоот албан шаардлагатай холбоотойгоор 17.8 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг бууруулсан гэх мэт.

3.4.9 Орлогын данс

Аймаг, сумдын 2024 оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 83,332.3 сая төгрөг, татварын бус орлогыг 6,956.0 сая төгрөг зэрэг нийт **90,288.3** сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **90,489.3** сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 201.0 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 11. Аймаг, сумдын төсвийн орлого

Орлогын нэр төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 он							
		Аймаг		Сумд		Нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	64,825.0	34,422.7	32,130.1	48,909.6	51,981.4	83,332.3	84,111.5	779.2	100.9
Хувь хүний орлогын албан татвар	30,398.2		249.9	39,155.5	43,506.3	39,155.5	43,756.2	4,600.7	111.7
ХХОАТ-ын буцаалт	(1,671.8)			(2,159.6)	(2,193.8)	(2,159.6)	(2,193.8)	(34.2)	101.6
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	21,050.0	29,700.0	26,181.0			29,700.0	26,181.0	(3,519.0)	88.2
Хөрөнгийн албан татвар	4,742.6	1,000.0	1,106.6	4,169.5	3,982.0	5,169.5	5,088.6	(80.9)	98.4
Бусад татвар, төлбөр, хураамж	10,306.0	3,722.7	4,592.6	7,744.2	6,686.9	11,466.9	11,279.5	(187.4)	98.4
Татварын бус орлого	4,834.6	3,467.8	1,823.0	3,488.2	4,554.8	6,956.0	6,377.8	(578.2)	91.7
Хүү, торгуулийн орлого	2,567.6	1,750.0	844.7	2,158.6	2,830.9	3,908.6	3,675.6	(233.0)	94.0
Нэр зааж ангилагдаагүй орлого	2,065.1	1,587.8	749.8	1,320.3	1,713.4	2,908.1	2,463.2	(444.9)	84.7
Түрээсийн орлого				9.3	10.5	9.3	10.5	1.2	
Хөрөнгийн орлого	171.9	130.0	228.5			130.0	228.5	98.5	
Хандив, тусламжийн орлого	30.0					-	-	-	-
НИЙТ ТӨСВИЙН ОРЛОГО	69,659.6	37,890.5	33,953.1	52,397.8	56,536.2	90,288.3	90,489.3	201.0	100.2

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3,937.4 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар тасрахад ААНОАТ-ын орлого 11.8 хувиар буюу 3,519.0 сая төгрөгөөр төгрөгөөр тасарсан нь гол нөлөө үзүүлсэн бөгөөд Сангийн яамнаас 12 сарын орлогыг тухайн сард нь хуваарилаагүйгээс шалтгаалсан байна.

Сумдын хувьд төсвийн орлогыг 7.9 хувиар буюу 4,138.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Сумдын орлогын төлөвлөгөөний давсан болон тасарсан орлогыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Сумдын төсвийн давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Ерөө сумаас бусад сумдын цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого /тус бүр 21.5-1,662.2 сая төгрөгөөр/ нийт 1,943.3 сая төгрөгөөр,
- **Газрын дуудлага худалдаа:** Мандал, Сант, Цагааннуур, Баянгол, Баруунбүрэн, Түшиг, Хушаат зэрэг сумдын газрын дуудлага худалдааны орлого нийт 1,085.2 сая төгрөгөөр,
- **Үйл ажиллагааны орлогын албан татвар:** Хувьцааны ногдол ашгийн орлогоос татвар суутгасантай холбоотойгоор бүх сумдын орлого /тус бүр 20.4-628.3 сая төгрөгөөр/ нийт 1,969.1 сая төгрөгөөр,
- **Хөрөнгийн орлого:** Хадгаламжийн хүүгийн болон хувьцааны ногдол ашгийн орлого өссөнтэй холбоотойгоор Сүхбаатар, Мандал, Хүдэр, Сайхан, Баруунбүрэн, Цагааннуур, Шаамар сумдын орлого нийт 451.7 сая төгрөгөөр,
- **Хөрөнгө борлуулсны орлого:** Иргэдийн хөрөнгийн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Орхонтуул, Шаамар сумдын орлого нийт 236.4 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Төлөвлөгөө тасарсан орлогууд:

- **Малын тоо толгойн албан татварын орлого:** Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас малын хөлийн татварын орлогыг сумдын суурь орлогод тооцож баталснаас Сант, Зүүнбүрэн сумд нь малын тоо толгойн албан татварыг хэт өндөр төлөвлөж, 218.7 сая төгрөг, Баянгол, Ерөө, Цагааннуур, Орхонтуул сумд уг татварын орлогыг төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүйгээс 272.8 сая төгрөг дутуу төвлөрүүлж, нийт 491.5 сая төгрөгөөр,
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал, ашигласны төлбөр:** 2024 онд Засгийн газраас “Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн авто замын карьерын төлбөрийг чөлөөлснөөс шалтгаалан эдгээр сумдын орлого 582.9 сая төгрөгөөр,
- **Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх модны хэмжээг бууруулснаас Хүдэр, Ерөө, Мандал, Цагааннуур, Түшиг, Алтанбулаг, Баруунбүрэн зэрэг сумдын ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлээний мод бэлтгэх зөвшөөрлийн эрхийн бичгийн орлого нийт 1,788.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын данстай холбоотой нийт **4,896.8** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Ерөө сум 2,389.4 сая төгрөг, Түшиг сум 77.6 сая төгрөг зэрэг нийт 2,467.0 сая төгрөгөөр төсвийн орлогын төлөвлөгөө, Сант сумын ЗДТГ 3.1 сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөг тус тус тасалсан,
- Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ 1,560.3 сая төгрөг, Гавшигай ус ОНӨААТҮГ 577.0 сая төгрөг зэрэг нийт 2,151.5 сая төгрөгийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг тасалсан,

- Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ 6.8 сая төгрөгийн ТАХ-ийн орон сууцны гэрээт орлогыг дутуу төвлөрүүлсэн,
- Жавхлант сум 21.0 сая төгрөгийн Малын тоо толгойн албан татварын давсан орлогыг сумын ИТХ-ын тогтоолгүйгээр, Цагааннуур сумын ЗДТГ 6.9 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг холбогдох шийдвэргүйгээр зарцуулсан,
- Орхонтуул сум БХНС барьцаа дансанд бусдаас 71.3 сая төгрөгийн, Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн алба 2.5 сая төгрөгийн хандивын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус төвлөрүүлж, зарцуулсан,
- Тохилог хараа ААТҮГ 21.2 сая төгрөгийн сумын төсвийн орлого болох хогны хураамжийн орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлж, зарцуулсан,
- Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ-ын үйл ажиллагааны орлого бус аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын 53.0 сая төгрөгийг татварын өрөнд суутгуулсныг нөхөн тооцож болон нөөцийн махны борлуулалтын авлагаас төвлөрүүлсэн 12.7 сая төгрөг зэрэг нийт 65.7 сая төгрөгийг махны нөөцийн дансанд төвлөрүүлээгүй, 2024 онд махны нөөц бүрдүүлээгүй, 93.9 сая төгрөгийн хураамжийн тасалбарыг дугаарлаж, баримтжуулаагүй, төлбөрийн цахим баримт олгодоггүй, үнэт цаасны тооцоо хийдэггүй зэргээр анхан шатны баримтын бүрдэл дутуу орлогын ажил гүйлгээг гүйцэтгэсэн.

3.4.10 Зардлын данс

Аудитын илрүүлэлт:

Зардлын данстай холбоотой нийт **1,317.1** сая төгрөгийн зөрчил илэрлээ. /Хавсралт №2-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Цалин, нэмэгдэл, урамшуулал, тэтгэмжийг 16 байгууллага зөрүүтэй тооцож, нийт **60.9** сая төгрөг илүү олгосон,
- Сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлсний нэмэгдэлд 2 сум **14.1** сая төгрөгийн нэмэгдлийг тооцож олгосон,
- Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 19 байгууллага **41.2** сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй,
- Батлагдсан бүтэц, орон тоог хэтрүүлэн 5 байгууллага **161.5** сая төгрөгийн цалин тооцож, олгосон,
- Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогчид холбогдох хууль эрхийн акт зөрчиж **9.2** сая төгрөгийн цалин олгосон,
- Цалингийн зардлаас Сүхбаатар сумын ЗДТГ 3.3 сая төгрөг, ИТХ 0.8 сая төгрөг, нийт **4.1** сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт тооцож олгосон,
- 2 байгууллага үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалин, НДШ **16.2** сая төгрөгийг төсвөөс барагдуулсан боловч гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй,
- Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ ажилчдын цалингаас суутгасан **11.8** сая төгрөгийн суутгалыг шилжүүлэлгүйгээр зориулалт бусаар зарцуулсан, Тохилог хараа ААТҮГ **6.7** сая төгрөгийн цалин зөрүүтэй тайлагнасан,
- Төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр ИТХ-д суудалтай намуудад аймаг 1 төлөөлөгчийн 5.0 сая төгрөгөөр тооцон нийт 185.0 сая төгрөг, Сүхбаатар сумын ИТХ 1

төлөөлөгчийн 2.0 сая төгрөгөөр тооцон **14.0** сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон,

- 9 байгууллага **192.6** сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- 32 байгууллага нийт **281.3** сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- 12 сум ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс **277.3** сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан,
- Шаамар сумын баяр наадамд **1.5** сая төгрөгийг төлөвлөснөөс илүү зарцуулсан,
- Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож, төлөвлөөгүйгээс **39.8** сая төгрөгийн зардлыг хэтрүүлсэн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн орлого, зарлагыг тус бүр **66,560.8** сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Орлого:

- Орон нутгийн суурь орлогыг 29,938.9 сая төгрөгөөр,
- Өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр,
- ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр,
- Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 7,118.4 сая төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 2,927.5 сая төгрөгөөр,

Зарлага:

- Төсвийн урсгал зардлыг 25,802.1 сая төгрөгөөр,
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг 27,927.2 сая төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 11,468.2 сая төгрөгөөр,
- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,363.3 сая төгрөгөөр гэх мэт.

Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан Сэлэнгэ аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 944.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **2,307.9** сая төгрөгөөр, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1,239.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **27,768.4** сая төгрөгөөр баталсныг үндэслэн аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2024 оны төсвийн нийт орлого, зарлагыг тус бүр **7,985.0** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **74,545.8** сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Орлого талд:

- ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1,239.3 сая төгрөг,

- Сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогыг 328.0 сая төгрөг,
- Татварын орлогыг 10,221.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,
- Урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,533.9 сая төгрөгөөр,
- Татварын бус орлогыг 2,270.0 сая төгрөгөөр тус тус бууруулахаар,

Зарлага талд:

- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 944.7 сая төгрөгөөр,
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг 1,218.0 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн урсгал зардлыг 5,518.1 сая төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 304.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр.

Сумдын 2024 оны төсвийн нийт орлогыг 50,606.9 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,315.5 сая төгрөгөөр /ХХС орсон/, туслах үйл ажиллагааны орлогыг 16.1 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 8,044.1 сая төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **60,982.6** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Ингэснээр Сэлэнгэ аймгийн нийт орлого, зарлагыг тус бүр **135,528.4** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 30 хөтөлбөрийн 51 арга хэмжээг санхүүжүүлэхээр **135,528.4** сая төгрөгийн төсөв батлагдсанаас 80,296.3 сая төгрөгийг урсгал зардалд, 52,419.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,812.9 сая төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 90,288.3 сая төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 27,768.4 сая төгрөгийг ОНХС-ийн шилжүүлгээс, 2,362.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, 16.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 15,093.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Код	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1300	Төсвийн шууд захирагчид	45,133.4	37,314.9	7,818.5	82.7
1301	Алтанбулаг	2,541.8	2,315.9	225.9	91.1
1302	Ерөө	12,504.0	10,098.5	2,405.5	80.8
1303	Зүүнбүрэн	2,572.7	2,092.5	480.2	81.3
1304	Мандал	15,617.9	11,872.9	3,745.0	76.0
1305	Орхон	2,065.0	1,795.8	269.2	87.0
1306	Сант	2,299.1	1,649.4	649.7	71.7
1307	Цагааннуур	4,590.9	3,492.3	1,098.6	76.1
1308	Баянгол	4,624.7	3,987.0	637.7	86.2
1309	Сайхан	7,852.3	6,558.2	1,294.1	83.5
1310	Орхонтуул	4,640.7	3,003.1	1,637.6	64.7
1311	Баруунбүрэн	3,029.4	2,364.1	665.3	78.0
1312	Шаамар	3,007.0	2,692.4	314.6	89.5
1313	Хүдэр	4,132.0	2,771.1	1,360.9	67.1
1314	Сүхбаатар	12,598.4	10,824.9	1,773.5	85.9
1315	Жавхлант	2,236.7	2,112.9	123.8	94.5
1316	Түшиг	3,612.1	2,637.8	974.3	73.0

1317	Хушаат	2,470.3	2,133.2	337.1	86.4
Нийт		135,528.4	109,717.0	25,811.4	81.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр 84,899.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, ОНХС-аас 26,784.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 1,984.1 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 108.1 сая төгрөг зэрэг нийт **113,776.4** сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 109,717.0 сая төгрөг буюу 81.0 хувьтай байгаа нь урсгал зардлыг 8,499.0 сая төгрөгөөр хэмнэж, хөрөнгийн зардал 14,862.8 сая төгрөгөөр, ХХС-ийн эргэж төлөгдөх зээл 2,449.5 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдсэнээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал нийт 8,499.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 3,052.6 сая төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,301.7 сая төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 119.7 сая төгрөгөөр,
- Нормативт зардал 5.5 сая төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 143.0 сая төгрөгөөр,
- Томилолтын зардал 73.8 сая төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,236.8 сая төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,003.1 сая төгрөгөөр,
- Урсгал шилжүүлэг 1,562.9 сая төгрөгөөр зэрэг.

Тайлант онд ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд 52,419.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 37,556.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгараагүйгээс олон удаа зарлагдсан, хугацаа алдсанаас он дамжин хэрэгжих болсон, дутуу хэрэгжсэнээс санхүүжилт олгоогүй зэрэг шалтгааны улмаас хөрөнгийн зардал 14,862.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

ХХС-аас 2,812.9 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 363.4 сая төгрөгийн зээл олгож, эргэж төлөгдөх зээлийг төлөвлөснөөс 2,449.5 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗДНХ-өөс 28.7 сая төгрөг, хандиваар 467.1 сая

төгрөг, бусад төсвийн захирагчаас 1,986.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,618.7 сая төгрөг зэрэг нийт 4,100.4 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, дараах зардлуудад 2,755.4 сая төгрөгийг зарцуулж, 1,345.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчийн НДШ-ийн зардалд 12.0 сая төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 8.5 сая төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 58.6 сая төгрөг,
- Нормативт зардалд 4.0 сая төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 291.7 сая төгрөг,
- Томилолт, зочны зардалд 10.0 сая төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 224.4 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,993.4 сая төгрөг,
- Урсгал шилжүүлэгт 132.8 сая төгрөг,
- Хөрөнгийн зардалд 20.0 сая төгрөг зэрэг нийт 2,755.4 сая төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 13,628.5 сая төгрөгийн 80 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 7,493.6 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ,
- Аймгийн ОНХО-ын хөрөнгөөр 4,946.6 сая төгрөгийн 40 төсөл, арга хэмжээ,
- Замын сангийн хөрөнгөөр 753.3 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ,
- БХНСАХЗ-аар 435.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ.

Худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас гүйцэтгэлээр шууд худалдан авах 6, ерөнхий гэрээ 1, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 24, нээлттэй тендер шалгаруулах 35, нийт 66 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 13. Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс							
			Шууд худалдан авах		Ерөнхий гэрээ		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ОНХС	29	5,838.5	1	18.3			9	755.0	19	5,065.2
Аймгийн ОНХО	31	4,347.6	5	88.0	1	75.0	12	869.9	13	3,314.7
Замын сан	2	753.3						-	2	753.3
БХНСАХЗ	4	435.0					3	211.5	1	223.5
Дүн	66	11,374.4	6	106.3	1	75.0	24	1,836.4	35	9,356.7

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: tender.gov.mn

3.6 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн:

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит 26 аж ахуйн нэгж нэгтгэгдсэнээс 22 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа явуулж нийт **5,353.9** сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлын дүн өмнөх оноос 1,598.4 сая төгрөгөөр буюу 23 хувиар буурсан байна.

Хүснэгт 14. ОНӨААТҮГ-ын ашиг, алдагдлын судалгаа

/сая төгрөгөөр/				
№	Байгууллагын нэр	Орон тоо	Өмнөх он	Тайлант он
1	Сэлэнгэ Цэнгэг ус	84	(588.0)	(745.6)
2	Гавшгай ус	76	(323.8)	(478.3)
3	Сэлэнгэ Энерго	126	(1,443.6)	(432.8)
4	Цант Орхон	52	(167.3)	(208.0)
5	Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй	8	(9.7)	(1.9)
6	Мандал энерго	32	15.8	(30.9)
7	Туулын хишиг	14	(78.7)	(91.0)
8	ТЭДДҮТТөв	-	-	-
9	Тохилог Хараа	41	(2,455.3)	(2,511.0)
10	Энх мэнд сувилал	6	0.3	17.5
11	Баянгол сувилал	5	(9.0)	(2.0)
12	Илдэнбүрэн	18	(373.5)	(34.5)
13	Хушаат Дуут хад	1	-	14.7
14	Цагааннуур тохижилт	4	4.3	2.0
15	Мандах Зэлтэр	1	(8.3)	3.4
16	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ	30	(583.8)	(392.2)
17	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ	56	(1,120.9)	(477.2)
18	Мандал шинэ агротехник	4	0.4	(6.3)
19	Төгөлдөр Ерөө	17	17.1	(4.5)
20	Мандал Хишиг хайрхан	-	-	-
21	Барилга захиалагч	6	141.6	141.5
22	Хүдэр Ойн анги	5	98.7	(114.5)
23	Хүдэр тохижилт	8	12.2	(6.9)
24	Сэлэнгэ орон сууц	4	(80.8)	4.6
	Дүн	598	(6,952.3)	(5,353.9)

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн өмчит газруудаас 16 нь үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 1.9- 2,511.0 сая төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадаагүйгээс гадна 2 аж ахуйн нэгж тус бүр 1 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ОНӨААТҮГ-ууд нь нийт 8,568.0 сая төгрөгийн авлага, 15,124.3 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Үүнд:

Хүснэгт 15. ОНӨААТҮГ-ын авлага, өр төлбөрийн судалгаа

/сая төгрөгөөр/			
№	Байгууллагын нэр	Авлага	Өр төлбөр
1	Урсгал ус	2,195.4	2,705.7
2	Гавшгай ус	1,682.7	2,242.1
3	Сэлэнгэ Энерго	1,266.1	9,104.6
4	Цант Орхон	13.8	4.6
5	Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй	7.9	9.1
6	Мандал энерго	65.2	166.6
7	Туулын хишиг	75.0	142.5

8	ТЭДДҮТТөв	26.9	385.4
9	Тохилог Хараа	12.7	21.5
10	Энх мэнд сувилал	8.9	-
11	Баянгол сувилал	-	8.1
12	Илдэнбүрэн	1.5	1.0
13	Хушаат Дуут хад	-	0.1
14	Цагааннуур тохижилт	5.0	3.0
15	Мандах Зэлтэр	-	-
16	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ	106.7	199.7
17	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ	20.1	43.0
18	Мандал шинэ агротехник	5.6	7.0
19	Төгөлдөр-Ерөө	0.1	5.7
20	Мандал Хишиг хайрхан	-	48.6
21	Барилга захиалагч	52.6	23.3
22	Хүдэр Ойн анги	0.8	0.5
23	Хүдэр тохижилт	0.6	1.1
24	Сэлэнгэ орон сууц	3,020.4	1.1
25	Сэлэнгэ баялаг ирээдүй	-	-
26	Баянгол хөгжлийн гүүр	-	-
	Дүн	8,568.0	15,124.3

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНӨААТҮГ-ын нийт авлагын 95.5 хувь буюу 8,164.6 сая төгрөгийг дараах авлагууд эзэлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ 3,020.4 сая төгрөгийн,
- “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ 2,195.4 сая төгрөгийн,
- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ 1,266.1 сая төгрөгийн,
- “Гавшгай ус” ОНӨААТҮГ 1,682.7 сая төгрөгийн гэх мэт.

Нийт өр төлбөрийн 92.9 хувь буюу 14,052.4 сая төгрөгийг дараах өглөгүүд бүрдүүлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын 9,104.6 сая төгрөгийн,
- “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2,705.7 сая төгрөгийн,
- “Гавшгай ус” ААТҮГ-ын 2,242.1 сая төгрөгийн гэх мэт.

Аймгийн төв Сүхбаатар сумын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг халаалт, дулаанаар хангах чиг үүрэгтэй, аймгийн хэмжээний хамгийн өргөн цар хүрээ бүхий Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд 2024 онд дараах ахиц, дэвшил гарсан байна. Үүнд:

- Өмнөх оноос авлагын үлдэгдлийг 193,457.3 мянган төгрөгөөр, өр төлбөрийг 244,966.5 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,
- Үйлдвэрлэлийн үр дүнгээр 432,780.2 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн буюу өмнөх оныхоос алдагдлыг 1,010,841.6 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт.

Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд гарсан ахиц, дэвшлийн жишээнээс харахад байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, удирдлага менежментийг зөв зохион байгуулсан нь үйлдвэрлэлийн үр дүнд эерэг өөрчлөлт гарч болохыг харуулж байна.

Иймд цэвэр ус нийлүүлж, бохир усыг татан зайлуулах, халаалт дулаан нийлүүлэх зэрэг стратегийн ач холбогдол бүхий чиг үүргийг хэрэгжүүлдэг бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, менежмент, санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэх, авлага, өр төлбөрийг эрс багасгах бүрэн боломжтой юм.

Аймаг, сумдын ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан ч үйл ажиллагаа явуулахгүй байгаа, үйл ажиллагаа нь тогтворжоогүй, өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа жижиг аж ахуйн нэгжүүдэд холбогдох хяналт шалгалт, судалгаа хийж тэдгээрийг ашигтай ажиллуулах боломжийг судлах, шаардлагатай бол хууль журмын дагуу татан буулгах арга хэмжээ авах нь зүйтэй юм.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгийн ашиглалт болон анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор, Ц.Отгонбаяр, аудитор О.Анхбаяр, Б.Наранцэцэг, Ж.Баясгалан, Э.Энхбүрэн нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/360 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 81,897.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 819.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 49 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажууллаа.

Аудитын илрүүлэлт:

1.Аймгийн ТЕЗ нь байгууллагуудын ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн нийт **19.8** сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Статистикийн хэлтсийн 100 жилийн ойн арга хэмжээнд 14.8 сая төгрөг,
- УБТЗ-ын Сүхбаатар өртөөний 75 жилийн ойн арга хэмжээнд 5.0 сая төгрөг гэх мэт.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр ... дэмжлэг олгох ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2.Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах **109.3** сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Сүхбаатар сумын ИТХ 20.0 сая төгрөг, Сайхан сум 25.0 сая төгрөг, Түшиг сум 30.0 сая төгрөг зэрэг нийт 75.0 сая төгрөгийн видео бичлэг, контент, баримтат кино бүтээсэн,
- Сүхбаатар сум 2.5 сая төгрөг, Мандал сум 2.1 сая төгрөг, Сайхан сум 2.0 сая төгрөг, Сант сум 3.5 сая төгрөг зэрэг нийт 10.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан,
- Сүхбаатар сумын ИТХ 5.3 сая төгрөг, аймгийн ИТХ 1.9 сая төгрөгийн шаардлагагүй бараа материалыг нөөцөлсөн,
- Аймгийн ЗДТГ 17.1 сая төгрөгийн шагнал, бэлэг дурсгалын зүйлс олгосон, бараа материал нөөцөлсөн гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Дээрх төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитуудаар тус бүр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

1.ТЕЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

- Мэдээлбэл зохих 157 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 7 төрлийн 17 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- “Мандал шинэ агротехник” ААТҮГ мэдээлбэл зохих 167 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- “Энхмэнд сувилал” ААТҮГ мэдээлбэл зохих 182 мэдээллээс 175 мэдээллийг хугацаанд, 5 мэдээллийг хугацаа хоцроосон бол 2 мэдээллийг огт мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх.

2. Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Алтанбулаг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Зүүнбүрэн сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Орхон сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 43 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Сайхан сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Сүхбаатар сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хүдэр сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Шаамар сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 12 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт мэдээлээгүй .
- Баруунбүрэн сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Орхонтуул сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Түшиг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Аймгийн Будалдан авах ажиллагааны газар нь мэдээлбэл зохих 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Аймгийн Байгаль орчны газар нь мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 ТБОНӨХБАУХА тухай хуулийн хэрэгжилт

Аудитын илрүүлэлт:

1. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн түвшинд түүвэрчлэн аудит хийгдсэн Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ нь нүүрсний **35.6** сая төгрөгийн, шатахууны **72.6** сая төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн

газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1-д “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар-Бараа 20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлэх.

2.Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудад ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- 9 байгууллага 781.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, /Хавсралт №3-д дэлгэрэнгүй харуулав./
- Мандал сум 35.9 сая төгрөгийн чанарын баталгааны 5 хувийн барьцааны дүнд баталгаажаагүй магадалшгүй ажлын зардал болон гүйцэтгэгчид олгох ёсгүй санхүүжилтийн дүнг оруулан тооцсон,
- Сант сум 14.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон.

Шийдвэрлэсэн нь: Дээрх төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 171 дүгээр “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 7.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 24.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгөгдсөнөөс “Насжилт өндөртэй авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол холбогдох байгууллагад уламжилж, данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлэх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 16. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1.8	2	1.8	100
Албан шаардлага	2	7.1	2	7.1	100

/сая төгрөгөөр/

Зөвлөмж	6	24.8	5	24.8	83.3
Нийт дүн	10	33.7	9	33.7	90

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас аймгийн ОНХС, ОНХО-ын төсөл, арга хэмжээний зөвхөн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулж, зөрчлийг “Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл”-д хийсэн аудитад тусгасан.

Харин худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны ХЭГ/2463 дугаар бүхий албан бичгээр аймгийн Засаг даргад ирүүлсэн чиглэлийн дагуу 17 сумын ЗДТГ болон ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдээх зорилгоор 77.6 сая төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн боловч хүлээн аваагүй байна.

Дээрх ажил, үйлчилгээг хүлээн авсан эсэхийг дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, 52 төсвийн байгууллага, 36 орон нутгийн сан, 26 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 131 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан 131 санхүүгийн тайлангаас төсөв, санхүүжилт, хамрах хүрээ, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөө харьцангуй багатай төсвийн шууд захирагчид, орон нутгийн төсөл, сангууд зэрэг 96 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 35 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт хүргүүллээ. Үүнд:

- 10 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”,
- 23 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”,
- 2 санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт.

Хүснэгт 15. “Хязгаарлалттай” болон “Сөрөг” дүгнэлт өгсөн байгууллагууд:

№	Байгууллагын нэрс	№	Байгууллагын нэрс
Хязгаарлалттай дүгнэлт			
1	Аймгийн ИТХ	13	Хушаат сумын ТТЗ
2	Алтанбулаг сумын ТТЗ	14	Хүдэр сумын ТТЗ
3	Баруунбүрэн сумын ТТЗ	15	Шаамар сумын ТТЗ
4	Баянгол сумын ТТЗ	16	Сэлэнгэ ҮЦСАА ОНӨААТҮГ
5	Ерөө сумын ТТЗ	17	Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
6	Жавхлант сумын ТТЗ	18	Тохилог хараа ААТҮГ
7	Зүүнбүрэн сумын ТТЗ	19	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ
8	Орхонтуул сумын ТТЗ	20	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ
9	Сайхан сумын ТТЗ	21	Мандал энерго ОНӨААТҮГ
10	Сант сумын ТТЗ	22	Туулын хишиг ОНӨААТҮГ
11	Сүхбаатар сумын ТТЗ	23	Гавшгай ус ОНӨААТҮГ
12	Түшиг сумын ТТЗ		
Сөрөг дүгнэлт			
1	Худалдан авах ажиллагааны газар	2	Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын Санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэл

Аймгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагуудын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит:

2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **288,424.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой **276,199.6** сая төгрөгийн алдааг залруулж, **100.7** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **8,162.2** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **14** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, **3,961.6** сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 74 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **1,055.9** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **126.5** сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж хүргүүлсэн байна.

Үүнээс:

1. Бие даасан дүгнэлт өгсөн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар:

ТЕЗ-ийн харьяа 5 шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргаснаас 3 санхүүгийн тайланд тус тус “Өөрчлөлтгүй”, аймгийн ИТХ-ын тайланд “Хязгаарлалттай”, ХААГ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **480.3** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **73.8** сая төгрөгийн алдааг залруулж, **9.6** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **357.2** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **2** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **39.7** сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **26.0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **5** зөвлөмж хүргүүлсэн байна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 17 сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргаснаас 3 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй”, 14 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **43,540.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **36,748.3** сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, **68.1** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, **3,697.2** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **6** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **3,027.0** сая төгрөгийн алдаа, зөрчилд 40 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **604.0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **126.6** сая төгрөгийн зөрчилд **11** зөвлөмж хүргүүлсэн байна.

3. Бие даасан дүгнэлт өгсөн ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж, бие даасан дүгнэлт өгсөн 13 ААТҮГ-аас 4 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 8 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **6,665.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **2,684.5** сая төгрөгийн алдааг залруулж, **10.1** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **3,186.5** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **3** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **784.6** сая төгрөгийн алдаа, зөрчилд 26 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **297.9** сая төгрөгийн албан шаардлага, **5** зөвлөмж хүргүүлсэн байна.

4. Аймгийн ТЕЗ-ийн түвшний санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн түвшний санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт **237,737.5** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс **236,693.0** сая төгрөгийн алдааг залруулж, **12.9** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, **921.3** сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **110.3** сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **128.0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **1** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **3** зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **236,777.0** сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **236,693.0** сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй **84.0** сая төгрөгийн алдааг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлт, зардлын төлөвлөгөө, бараа материалын дансны ангиллыг зөрүүтэй илэрхийлсэн, нийт **236,693.0** сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- *Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны орлогыг 122,221.6 сая төгрөгөөр илүү, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 111,299.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,*
- *Авлагын тодруулгад олон жилийн насжилттай авлагын ангиллыг 93.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,*
- *Аймгийн ОНХО-ын бараа үйлчилгээний бусад зардлын 1,893.3 сая төгрөгийн төлөвлөгөөг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд бүртгэсэн,*
- *Түшиг сум 678.7 сая төгрөгийн ОНХС-аас санхүүжих эх үүсвэрийг ОНХНС-аас санхүүжихээр тайлагнасан,*
- *Түшиг сум 506.4 сая төгрөгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг биологийн хөрөнгө дансаар дамжуулан ашиглагч байгууллагад шилжүүлсэн.*

Залруулаагүй алдаа:

1. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд түүвэрчилсэн байдлаар нэгтгэгдсэн дараах ААТҮГ-ын нягтлан бодох бүртгэл, тодруулга тайланд буруу тусган илэрхийлсэн 84.0 сая төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

Мандал шинэ агротехник ААТҮГ нь нийт 1.7 сая төгрөгийн:

- *Иргэн Г.Батцэнгэлээс авах 1.2 сая төгрөгийн зоорины түрээсийн орлого, авлагыг дутуу тайлагнасан,*
- *Нийгмийн даатгалын тайланд сахиул Б.Чимгээгийн 0.5 сая төгрөгийн амралтын цалинг тайлагнаагүй,*

Баянгол сувилал ААТҮГ нь нийт 24.9 мянган төгрөгийн:

- *Санхүүгийн тайланд 11.7 сая төгрөгийн зээлийн өр төлбөрийг тусгаагүй,*
- *Орлогын тайланд 13.2 сая төгрөгийн борлуулалтын орлогыг илүү илэрхийлсэн,*

Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ нь 55.9 сая төгрөгийн:

- Санхүүгийн тайланд 6.1 сая төгрөгийн халаалтын авлагыг тусгаагүй,
- Орлогын тайланд 49.8 сая төгрөгийн борлуулалтын орлогыг илүү илэрхийлсэн,

Энхмэнд сувилал ААТҮГ нь нийт 1.5 сая төгрөгийн:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдаж авсан 1.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан гэх мэт.

Өгсөн зөвлөмж: Буруу илэрхийллийг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

5.1 Төлбөрийн акт:

1. Цалин, нэмэгдэл, тэтгэмжийг илүү тооцож олгосон **12.9** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Энхмэнд сувилал ААТҮГ:

- Дарга А.Энхбилэг тасралтгүй 5 жил их эмчээр ажилласан гэх үндэслэлээр өөртөө тушаал гаргаж, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 10.2 сая төгрөгийн /6 сарын сарын цалинтай тэнцэх/ мөнгөн тэтгэмж олгосон,
- Тооцооллын алдааны улмаас 6 албан хаагчид 0.4 сая төгрөгийн цалин илүү олгосон,
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан 0.4 сая төгрөгийн төлбөрийн актыг байгууллагын орлогоос барагдуулсан.

Баянгол сувилал ААТҮГ:

- Тооцооллын алдаанаас дарга Х.Отгонцэцэгт 0.3 сая төгрөгийн, нягтлан бодогч С.Ариунбатад 0.4 сая төгрөгийн, сувилагч Ц.Билгээд 0.1 сая төгрөгийн, тогооч Б.Баярхишигт 0.1 сая төгрөгийн зэрэг нийт **0.9** сая төгрөгийн цалин илүү олгосон,

Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ:

- Механик М.Мөнхжаргалд 0.2 сая төгрөгийн, галч Ж.Эрдэнэбатад 0.2 сая төгрөгийн, Б.Цэндэд 0.5 сая төгрөгийн, Л.Даваад 0.1 сая төгрөгийн зэрэг нийт **1.0** сая төгрөгийн цалин илүү олгосон.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:” 20.2.5: “... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/8531,136 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэг, аймаг дахь төрийн болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа

эмнэлгийн болон эмнэлгийн бусад мэргэжилтэнд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалин, тэтгэмжийг нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Аймгийн ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс жил бүр тогтмол гардаг, урьдчилан төлөвлөх боломжтой, аймгийн ЗДТГ-ын болон бусад байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой **77.3** сая төгрөгийн дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Цэрэг татлагын зардалд 10.7 сая төгрөг,
- Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалт болон зөвлөгөөний арга хэмжээнд 18.2 сая төгрөг,
- Шинэ жилийн ёслолын буудлагын салютын зардалд 2.3 сая төгрөг,
- Засаг даргын жуух бичиг хэвлүүлэхэд 16.3 сая төгрөг,
- “Алтан намар 2024” арга хэмжээний зардалд 5.1 сая төгрөг,
- Зочин төлөөлөгч хүлээн авахад 13.2 сая төгрөг,
- Сант сумын ЗДТГ-т тус сумаас төрөн гарсан алдартнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 8.0 сая төгрөгийн,
- Мандал сумын Түнхэл тосгоны Соёлын төвд Наурызын баяр тэмдэглэхэд зориулж дэмжлэг 3.5 сая төгрөгийн гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1 дэх “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна: 2.1.5: “... урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДҮАХХ-ийн батлагдсан төсвөөс улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон бусад урсгал зардалд **нийт 413.6** сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

1. Хөрөнгө худалдан авах:

- Нийтийн номын сан, сумдын соёлын төвүүдэд 64.0 сая төгрөгийн өртөг бүхий 23 ширхэг зөөврийн компьютер,
- Санхүү хяналт, дотоод аудитын албанд 2.2 сая төгрөгийн принтер,
- Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтанд 11.0 сая төгрөгийн компьютер, дрон,
- Эрүүл мэндийн даатгалын газарт сканер худалдан авахад 2.3 сая төгрөгийг,
- АДБ-ийн Сэлэнгийн долгио чуулгад гадна, дотно камержуулалтад 29.1 сая төгрөгийг,
- Эрүүл мэндийн газарт хурлын өсгөгч худалдан авахад 9.1 сая төгрөгийг,

- Цагдаагийн газарт төлө камерын хяналтын төвийн тохижилтод 10.4 сая төгрөгийг,
- ГИХГ-ын Хойд бүс дэх газарт албан байр болон ажилчдын орон сууцны засварт 39.3 сая төгрөгийг,
- ХЦ-ийн 243-р ангид тоног төхөөрөмж худалдан авахад 14.8 сая төгрөгийг,
- Сумдын ЗДТГ, Захирагчийн алба болон Түшиг сумын ЕБС зэрэг 10 байгууллагад 63.4 сая төгрөгийн өртөг бүхий 31 ширхэг суурин компьютер,
- Сумдын ЗДТГ болон ЭМТ, ЕБС, цэцэрлэг зэрэг 14 байгууллагад тоног төхөөрөмж, засварын зардалд нийт 122.7 сая төгрөгийг гэх мэт.

2. Цэргийн штабын 45 хоногийн дүйцүүлэх албаны сургалтад **14.7** сая төгрөг,

3. Ерөө сумын ЗДТГ-ын өмнөх талбай, самбарын зураг төсөв хийлгэхэд **20.0** сая төгрөг,

4. Аймгийн баяр наадмын хурдан морины уралдааны бай шагналд **10.6** сая төгрөг гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас сумдын ХХС-ийн 2022-2023 оны үйл ажиллагааг хамруулан хийсэн дотоод аудитаар 8 сумын 211 иргэнээр хугацаа хэтэрсэн зээлийн алдангийг тооцож, төлүүлээгүй зөрчилд 243.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг хангуулахдаа 8 сумын ХХС-ийн эх үүсвэрээс **153.9** сая төгрөгийг аймгийн төсвийн нэр заагдаж, ангилагдаагүй бусад орлогын дансанд шилжүүлсэн нь зөрчлийг арилгах бус хэлбэрийг өөрчилж, хоршоог дэмжих зориулалт бүхий уг сангийн эх үүсвэрийг бууруулж, зорилго зорилтыг алдагдуулсан сөрөг үр дагавар үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д “Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1 дэх “Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ... санхүүгийн хяналт шалгалт хийх, ... тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 1.5 дахь “Сангийн хөрөнгө нь суманд хоршоонд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, ...д зориулагдана”, 2.1 дэх “Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ: 2.1.5: “хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн сумдын ХХС-ийн эх үүсвэрийг буцаан төвлөрүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Сумдын ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан ААТҮГ-уудын санхүүгийн тайланг сумдын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэлгүйгээр аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэн, тайлагнаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Авлагын дансанд бүртгэлтэй, 1990 оноос үүссэн аймгийн төсвөөс олгосон **276.5** сая төгрөгийн авлага /1990 оноос эхлэн үүссэн аймгийн төсвөөс 13 аж ахуйн нэгжид олгосон 47.0 сая төгрөгийн, уринш боловсруулалтад 12 суманд олгосон 20.0 сая төгрөгийн, хүнсний хөтөлбөрийн дагуу 64 иргэнд олгосон 1.1 сая төгрөгийн, улсын нөөцөөс хадлан тэжээл бэлтгэхэд 11 аж ахуйн нэгжид олгосон 45.7 сая төгрөгийн зээлийн, 2001 онд үүссэн аж ахуйн нэгж байгууллагаас авах татварын 162.2 сая төгрөгийн авлага, өрхийн амьжиргаа дэмжих төслийн 0.3 сая төгрөгийн гэх зэрэг/-ын үлдэгдэлд дүн шинжилгээ хийгээгүй, үр дүнг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ...ыг хянах, 20.2.6 дахь “... төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэв.

5. Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын шийдвэрээр томилогдсон төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчид, ОНӨААТҮГ-ын удирдлага зэрэг 4 албан тушаалтан нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа зөрчлийг давтан гаргасан болон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн болон санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан байна. Үүнд:

- Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Октябрь,
- Цэнгэг Ус ААТҮГ-ын дарга А.Алтансүх,
- Хушаат сумын Засаг дарга Н.Захирахбаатар,
- Гавшгай Ус ААТҮГ-ын дарга Б.Үүрдмөнх,

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “*...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан бол тухайн албан*

хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой:

1.1 Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын хөрөнгөд бүртгэлтэй 34.5 сая төгрөгийн анхны үнэтэй, үлдэх өртөггүй Тоёота Хариер маркийн автомашиныг ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр тогтоолоор 10.0 сая төгрөгөөр үнэлэн Орхонтуул сумын ЗДТГ-т шилжүүлснийг тус газар хүлээн аваагүй, бүртгэлд тусгаагүй атал ИТХ-ын 2024 оны 158 дугаар тогтоолоор актлах шийдвэр гарч, иргэн Д.Гарамсүрэнгээс 1.5 сая төгрөгийн орлогыг аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлж, бүртгэлээс хассан байна. Уг хөрөнгийн эзэмшил, ашиглалт болон ИТХ-аас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд аймгийн ТЕЗ-ийн зүгээс хяналт тавиагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх “Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж, холбогдох баримт материалыг бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой:

2.1 Илрүүлэлт: ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан дараах ААТҮГ -ууд нь 26.3 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй буюу хүчин төгөлдөр анхан үшатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Баянгол сувилал ААТҮГ 4.4 сая төгрөг,
- Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ 21.9 сая төгрөг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх .

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	5	236,693.0			5	236,693.0	5	236,693.0				
Мандал шинэ агротехник ААТҮГ	2	1.7			2	1.7			2	1.7	2	1.7
Энхмэнд сувилал ААТҮГ	1	1.5			1	1.5			1	1.5	1	1.5
Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ	2	55.9			2	55.9			2	55.9	2	55.9
Баянгол сувилал ААТҮГ	2	24.9			2	24.9			2	24.9	2	24.9
Дүн	12	236,777.0			12	236,777.0	5	236,693.0	7	84.0	7	84.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	6	921.3			4	921.3	1		1	4		
Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ	2	22.9	1	1.0			1	21.9				
Мандал шинэ агротехник ААТҮГ												
Энхмэнд сувилал ААТҮГ	1	11.0	1	11.0								
Баянгол сувилал ААТҮГ	2	5.3	1	0.9			1	4.4				

Дүн	11	960.5	3	12.9	4	921.3	3	26.3	1	5		
-----	----	-------	---	------	---	-------	---	------	---	---	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Аймгийн ТЕЗ	1	-					1	-
Мандал шинэ агротехник ААТҮГ	1	-					1	-
Энхмэнд сувилал ААТҮГ	1	-					1	-
Дүн	3	-					3	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ	1	108.2			1	108.2		-
Дүн	1	108.2			1	108.2		-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт								
Аймгийн ТЕЗ	1	19.8			1	19.8		
Дүн	1	19.8			1	19.8		-
Нийт дүн	5	128.0			2	128.0	3	-

Авлага, өр төлбөрийн данстай холбоотой зөрчлийн нэгтгэл

Хавсралт №1

/сая төгрөг/

1324100015 9055436

Д/д	Байгууллагын нэр	Зөрчлийн утга		Нийт зөрчлийн дүн
		Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас		
		Авлага үүсгэсэн	Өр төлбөр үүсгэсэн	
1	Алтанбулаг сумын ИТХ		0.7	0.7
2	Алтанбулаг сумын ЗДТГ	19.6	29.1	48.7
3	Баянгол сумын ИТХ		2.9	2.9
4	Баянгол сумын ЗДТГ	2.7		2.7
5	Жавхлант сумын ЗДТГ	0.5		0.5
6	Зүүнбүрэн сумын ЗДТГ	3.0		3.0
7	Мандал сумын ИТХ	0.1	1.7	1.8
8	Орхон сумын ИТХ		3.3	3.3
9	Сайхан сумын Хот тохижуулах газар		6.5	6.5
10	Сүхбаатар сумын ИТХ	3.9		3.9
11	Сүхбаатар сумын ЗДТГ		0.3	0.3
12	Хушаат сумын ЗДТГ		2.3	2.3
13	Аймгийн ЗДТГ		3.4	3.4
14	Худалдан авах ажиллагааны газар	28.0		28.0
15	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ	1.4		1.4
16	Цант Орхон ОНӨААТҮГ	1.4		1.4
17	Гавшгай ус ОНӨААТҮГ		17.0	17.0
	Нийт дүн	60.6	67.2	127.1

Зардлын данстай холбоотой зөрчлийн нэгтгэл



Д/д	Байгууллагын нэр	Зөрчлийн утга					Нийт зөрчлийн дүн
		Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.	Мөнгөн урамшууллаас ХХОАТ суутгаагүй.	Батлагдсан бүтэц, орон тоог хэтрүүлэн цалин тооцож, олгосон.	Анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгасан.	Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.	
1	Алтанбулаг сумын ИТХ	0.6				4.2	4.8
2	Алтанбулаг сумын ЗДТГ	0.2				32.0	32.2
3	Баруунбүрэн сумын ИТХ				0.6		0.6
4	Баруунбүрэн сумын Засаг дарга					3.0	3.0
5	Баруунбүрэн сумын ЗДТГ		1.6			8.2	9.8
6	Баянгол сумын Засаг дарга					21.7	21.7
7	Баянгол сумын ИТХ					4.6	4.6
8	Баянгол сумын ЗДТГ	0.4	5.3				5.7
9	Ерөө сумын Засаг дарга					35.8	35.8
10	Ерөө сумын Сумын ИТХ		0.9			1.9	2.8
11	Ерөө сумын Сумын ЗДТГ	0.5	3.8			11.8	16.1
12	Ерөө сумын Бугант захирагчийн алба	0.5	0.8	25.3		31.4	58.0
13	Жавхлант сумын Засаг дарга					3.9	3.9
14	Жавхлант сумын ИТХ		0.9				0.9
15	Жавхлант сумын ЗДТГ	0.3	3.0			0.5	3.8
16	Зүүнбүрэн сумын Засаг дарга					2.0	2.0
17	Зүүнбүрэн сумын ИТХ					0.5	0.5
18	Зүүнбүрэн сумын ЗДТГ					2.3	2.3
19	Мандал сумын Засаг дарга					17.3	17.3
20	Мандал сумын ИТХ	2.1				0.5	2.6
21	Мандал сумын ЗДТГ		6.3		10.0	0.5	16.8
22	Мандал сумын Түнхэл захирагчийн алба		1.3				1.3
23	Мандал сумын Хэрх захирагчийн алба		0.6			2.5	3.1
24	Орхон сумын Засаг дарга					1.4	1.4
25	Орхон сумын ЗДТГ		2.4				2.4
26	Орхонтуул сумын Засаг дарга					2.0	2.0
27	Орхонтуул сумын ИТХ	0.1				0.2	0.3
28	Орхонтуул сумын ЗДТГ	0.6		3.6		1.1	5.3
29	Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	0.6		62.0		0.6	63.2
30	Сайхан сумын ИТХ		0.9			1.4	2.3
31	Сайхан сумын ЗДТГ		2.9			10.4	13.3
32	Сайхан сумын Номгон захирагчийн алба		0.7				0.7
33	Сант сумын Засаг дарга					10.5	10.5
34	Сант сумын ИТХ					0.7	0.7
35	Сант сумын ЗДТГ					1.5	1.5
36	Сүхбаатар сумын Засаг дарга					170.3	170.3
37	Сүхбаатар сумын ИТХ					56.2	56.2
38	Сүхбаатар сумын ЗДТГ	2.6	1.0	61.3			64.9
39	Түшиг сумын Засаг дарга					3.1	3.1
40	Түшиг сумын ИТХ					0.5	0.5
41	Түшиг сумын ЗДТГ					0.5	0.5
42	Хушаат сумын Засаг дарга					2.0	2.0
43	Хушаат сумын ЗДТГ					5.8	5.8

44	Хүдэр сумын ИТХ		0.9			6.2	7.1
45	Хүдэр сумын ЗДТГ	11.5	2.2			27.7	41.4
46	Цагааннуур сумын Засаг дарга					6.2	6.2
47	Цагааннуур сумын ЗДТГ	1.2	1.5				2.7
48	Шаамар сумын ИТХ					2.8	2.8
49	Шаамар сумын ЗДТГ				10.2		10.2
50	Шаамар сумын Дулаанхан захирагчийн алба					5.0	5.0
52	Аймгийн ИТХ		4.2			37.1	41.3
53	Аймгийн ЗДТГ	1.7				18.7	20.4
54	Худалдан авах ажиллагааны газар			9.3			9.3
55	Байгаль орчны газар	30.4					30.4
56	Сэлэнгэ ҮЦСАА ОНӨААТҮГ				3.3		3.3
57	Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ				41.6		41.6
58	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ	7.6					7.6
59	Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ				118.5	2.1	120.6
60	Туулын хишиг ОНӨААТҮГ				0.6		0.6
61	Мандал энерго ОНӨААТҮГ				7.8		7.8
	Дүн	60.9	41.2	161.5	192.6	558.6	1,014.8

Хавсралт №3

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион
байгуулаагүй зөрчлийн нэгтгэл

1324100015 9055436
/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Зөрчлийн утга	Нийт зөрчлийн дүн
		Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	
1	Баруунбүрэн сумын Засаг дарга	289.5	289.5
2	Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	48.0	48.0
3	Орхонтуул сумын Орон нутгийн хөгжлийн сан	40.0	40.0
4	Сүхбаатар сумын ИТХ	22.0	22.0
5	Хушаат сумын ЗДТГ	28.7	28.7
6	Шаамар сумын ЗДТГ	28.9	28.9
7	Аймгийн ИТХ	26.0	26.0
8	Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ	157.0	157.0
9	Туулын хишиг ОНӨААТҮГ	140.9	140.9
	Нийт дүн	781.0	781.0